

МОНГОЛ, ГЕРМАН ӨВӨРМӨЦ ХЭЛЦ ҮГЭНД МЕТАФОР (шилжмэл утга)-ЫГ ТҮГЭЭМЭЛ ХЭРЭГЛЭСЭН НЬ

А.Цэрэнчулуун⁷⁶

Товч утга: Монгол, герман хэлний өвөрмөц хэлц үгэнд метафор (шилжсэн утга)-ыг хэрхэн хэрэглэж байгаа хийгээд орчин үеийн хэлэнд түүний хэрхэн тэлж байгааг зарим нэг жишээ авч тайлбарлав.

Түлхүүр үг: амаа үдүүлэх, ганзага дүүрэн; гахай шахах, гурилдах, загалмайлсан эцэг, метафор⁷⁷, мод цагаалах, монголчлох (аргацаах); морь харах; морьтой явах (*Glück haben*); мөнгө угаах, мөнгөнд умбах, мөнгө уух, нийгмийн шаар, өөрийгөө ялах, тэнгэр харуулах (алах), улаан коммунист, үзүүр булаацалдах, хийморьтой (*glücklich*); хов базах, хуулийн цоорхой, хүний шаар, шар гозолзох, хээгээ алдах (ичихээ мэдэхгүй); царцаах, цөм хийх, цэг тавих, чирэгдэх, чөдөрлөх, шилэн данс, шордох, яс хаях.

Аливаа амьд хэл үргэлж шинэчлэгдэн баяжиж, зарим хуучин үг хэллэг цагийн аясаар гээгдэх, зарим нь шинэ утга санаа авч сэргээгдэн хэрэглэгдэх нь хэвийн үзэгдэл юм.

Түүний нэгэн адил хүний сэтгэхүй, дүрслэл, хэл яриа зүйрлэлээр баян, тэр дундаа монголчууд нүүдлийн соёлтой ард түмний хувьд байгаль орчин, байгаль, цаг уурын үзэгдэл, малчин түмний хувьд малын ааш зан, шинж төрхийг тусгасан зүйрлэлийг ардын аман зохиол, орчин үеийн утга зохиолд тусгасан нь тун их ажээ.

Монголчууд ч уламжлалт нүүдлийн мал аж ахуйн соёлтой, бас нүүдэл суудал, аян дайн, эргэл мөргөл, бадарчлал, аялалаар тив тивээр явж, олон янзын соёлтой танилцаж, өөр өөр соёлыг алгуур идээшүүлж авсны зэрэгцээ, өөрийн соёлыг ч бас түгээж явсан өвөрмөц нэгэн ард түмэн билээ. Тэр хэрээрээ ч зүйрлэлээр баян бөгөөд түүхэн тодорхой нөхцөлд нэг үе дорнын соёлтой орнуудтай, нэг үе оросын соёлтой уялдаж, соёлоо харилцан солилцож ирсэн бол эдүгээ дэлхийчлэл, мэдээллийн эрин үед баруун европ, америкийн соёлын хэл, сэтгэлгээний өвөрмөц зүйрлэл буюу метафорчлал орж ирж, хэл сэтгэлгээнд идээшиж байна.

Монгол хэл сэтгэхүйд “луу унжих” гэдэг хэлц байдаг. Говь нутагт хүмүүс хур борооны хүслэн болоод байхад үүл унжаад яах аргагүй бороо орох нь гэтэл жаахан шороо босоод үүл сарнин алга болдог. Зарим хүн хоосон горьдоогоод байж, байж амалснаа биелүүлэхгүй хүлээлгээд байхыг битгий “луу унжаад байгаарай” хэмээн

⁷⁶ Орчуулагч, судлаач

⁷⁷ Энэ нь [Латин](#) хэлний *metaphora* “зөөвөрлөх”, [грек](#) хэлний *μεταφορά* (метафора), “шилжүүлэх” гэсэн утгатай үгнээс гаралтай, утга шилжүүлэн хэрэглэх гэсэн санааг илтгэх ажээ.

дээрх утгыг шилжүүлэн хэлдэг билээ. Энэ бол хүний цаг агаарын үзэгдлийг хүний ааш занд шилжүүлэн хэрэглэж байгаа хэрэг билээ.

Метафорчлах буюу утга шилжүүлэн хэрэглэх

Метафор нь латин хэлний "metaphora"(зөөвөрлөх), грек хэлний "μεταφορά" (шилжүүлэх) гэх мэт утгатай үгнээс үүдэлтэй ажээ. Өөрөөр хэлбэл, нэг зүйлд шууд утгаар хэрэглэдэг хэллэгийг өөр нэг зүйлд шилжсэн утгаар хэрэглэхийг метафорчлах гэж хэлдэг байна хэмээн ойлгож болох мэт санагдах ажээ.

Монгол хэлэнд хэдийнээс хэрэглэсээр ирсэн шилжсэн утгатай үг хэрэглээ:

ам авах, ам алдах, ам таглах, амаа барих ганзага дүүрэн; гурилдах, мод цагаалах, морьтой явах, мөнгө уух, хор найруулах, хорхойсох, хөлжих, хужир, хээгээ алдах (ичихээ мэдэхгүй); чирэгдэх, чөдөрлөх, шар хөдлөх, шордох, яс хаях,

Социализмыг өрнүүн байгуулах үед орж хэвшсэн, шилжмэл утгатай үгс:

алаг үзэх, алтан хошуу өргөх, *арын хаалга*, биеэ барих, газар авах, гахай шахах, гурилдах, *данхраадуулах*, зүрхээ авах, мод цагаалах, монголчлох (аргацаах); *нагдааванд оруулах*, нийгмийн шаар, нуруугаа авах, *татлага*, улаан коммунист, хүний шаар, цэг тавих, чирэгдэх, чөдөрлөх г.м.

Зах зээлийн тогтолцоотой хүмүүнлиг ардчилсан нийгмийн үед монгол хэлэнд орж ирж, хэвшсэн шилжмэл утгатай үгс:

ажил хайх, ажил хаях, ажил хаях, амаа үдүүлэх, баялгийн хараал хүрэх, лоом ноосоор зүлгэж тэмнэ хийх, мессежний англи хэл, мөнгө босгох, мөнгө уух, өөрийгөө ялах, хов базах, туушиндах, хор найруулах, хорхойсох, хуулийн цоорхой, царцаах, цөм хийх, шар хөдлөх, шилний цаанаас чихэр долоолгох, шилэн данс, царцааны нүүдэл (*Wählerwanderungen*), давхар дээл, манан, хаврын синдром, цүнх баригч, шүгэл үлээгч

Эдүгээ дэлхийчлэл, мэдээллийн эрин үед гадаад харилцаа улам бүр хөгжиж, нэгэн үе хол байсан ертөнц мэдээлэл, технологийн эрин үед ойртохын хэрээр хүмүүсийн сэтгэлгээ улам бүр өөрчлөгдөн хуучин байсан үг хэлцийг өөр зүйлд шилжүүлэн өөр утгаар хэрэглэн, шинэ шинэ ойлгоц сэтгэлгээ буй болж байна. Жишээ нь өнөө цагт идэвхтэй хэрэглээнд байгаа заримаас нь дурьдвал: *загалмайлан эцэг (God father)*, *хөгжлийн өдөөгч (growth catalyst)*, *алтан боломж (golden chance)*, *санхүүгийн ертөнц (financial world)*, *матрын нулимс унагах (Krokodilstränen weinen, to shed crocodile tears)*, *“ертөнцөөс тасрах”*, *“мөнгө угаах”(Geld waschen)* зэрэг үг хэллэг нь хэдийгээр шилжсэн утгатай ч монгол төрхөнд хэдийн оржээ.



Ерээд оноос хойш дэлгэрсэн, ингэхдээ зарим нэг нь бүр өвөрмөц хэллэг (идиом) болтлоо монгол хэлэнд бэхэжсэн байна⁷⁸.

Алив үндэстэн бүхэнд өөрийн амьдрах орчин байгаль, цаг уурын нөхцөл, ахуй байдал, хэл, соёл, сэтгэлгээний онцлогтой холбогдсон олон шилжмэл утгатай үг хэллэг (метафор) байдаг байна.

Герман болон европын хэлэнд ч бас шилжмэл утгатай үг олон байх ажээ. Энэ нь техник хөгжихийн хэрээр улам баяжиж байх ажээ.

Нэгэн жишээ:

Мөнгө угаах (*Geld waschen*)⁷⁹, мөнгөнөөс өмхий үнэртдэггүй⁸⁰ (*Geld stinkt nicht*), мөнгөнд умбах (*in Geld schwimmen*), их мөнгөтэй байх, орвонгоор нь эргүүлэх (*sich um hundertachtzig Grad drehen*) хөмөрч орхих, гэмгүй царайлах (*sich die Hände in Unschuld waschen*), огтхон ч эв дүйгүй (*zwei linke Hände haben*), шавгийн гал шиг (*viel Lärm um nichts*), удаж ухаарах, (*eine lange Leitung haben*), хүртээлгүй юм ярих (*Makulatur reden*), гал дээр тос хийх (*Öl ins Feuer gießen*) ялих, шалихгүй зүйл (*ein Sturm im Wasserglas*), банзанд нь тусах (*eine Fahrkarte schießen*), хуучин тавыг ховхлох хэрэггүй (*schlafende Hunde soll man nicht wecken*).

Нэг жишээ хэлэхэд, орчин үед хамгийн түгээмэл хэрэглэж байгаа нэг шилжмэл утгатай өвөрмөц хэлц бол “мөнгө угаах” (*Geld waschen*) юм. Мөнгийг угаах гэдэг үгчлэн ойлговол ухаж мэдэхэд хэцүү юм. Ямар ч улсын цаасан мөнгөн дэвсгэртийг угаах гэдэг шууд утгаараа ойлгох боломжгүй. Зөвхөн шилжсэн утгаар ойлгогдоно. Хөдөлмөрийн бус аргаар *авлигал, хүн худалдаалах, янханчлал, хар тамхины наймаа* зэргээс олсон бохир бэлэн мөнгийг элдэв аргаар хөдөлмөрийн шударга орлогоор олсон мэт болгон дансны мөнгө болгохыг “мөнгө угаах” гэдэг байна.

Нэгэн жишээ:

seinem Affen Zucker geben (сармагчинд чихэр өгөх) монголоор бол “улам хөөргөх, дэврээх” гэсэн утга илэрхийлдэг бол *den Amtsschimmel reiten*, (албаны морь

⁷⁸ ЦАГ ҮЕ БА МЕТАФОРЧЛАХ СЭТГЭЛГЭЭ Ц.МАГСАР (МУБИС-ийн ОХУЗТэнхмийн профессор, хэл бичгийн ухааны доктор)

⁷⁹ ХБНГУ-ын Холбооны Сангийн яамны барагцаалсан тоогоор жилд 100 саяар тоологдох бохир евро угаагдаж байдаг ажээ.

⁸⁰ Мөнгөнөөс өмхий үнэртдэггүй

Энэ үгийг ромын хаан Веспасиан (МЭ 69-79) их мөнгө олохын тулд боломжтой бүх юмнаас татвар авч эхэлжээ. Бие засах газраас татвар авчээ. Хүү нь үүнд дургүйцэхэд хүүгийн хамар дор жорлонгийн татварт авсан мөнгөнөөс нэгийг бариад эндээс муухай үнэр гарч байна уу гэхэд “үгүй” гэжээ. Ийнхүү “*pecunia non olet*” (“*Geld stinkt nicht*”) мөнгөнөөс өмхий үнэртдэггүй гэсэн алдарт хэллэг гарчээ. Энэ шилжсэн утгатай үгийг зах зээлийн орны хүмүүс бүхэн хэрэглэдэг.

унах) гэдэг нь товчхон хэлэхэд “хүнд суртал гаргах”, *einen langen Arm haben* (урт гартай байх), гэдэг нь монголоор бол хэм хэмжээнээс хэтэрсэн урт гартай хэн нэгнийг хэлээгүй харин “эрх мэдэл нөлөө ихтэй хүн” гэсэн утгаар хэрэглэгдэх болой.

Герман хэлний *gut Wetter machen*⁸¹ (тэнгэр сайн болгох) аянд гарах, зугаацахаар явахад тэнгэр сайхан байвал таатай. Хэн нэгэн хүнтэй уулзах, хэн нэгнээс юм гуйхад тэр хүн сайхан зантай байвал ажил бүтэмжтэй байх нь мэдээж хэрэг. Тэгэхлээр юун түрүүн уулзах хүнийхээ ааш занг зөв хөглөх, сайхан ааштай болгохыг шилжсэн утгаар “тэнгэр сайхан болгох” гэдэг ажээ. Тэгэхдээ герман хэлний “Wetter” гэдэг үг одоо цаг агаар/тэнгэр гэсэн утгатай ч дээр үед “ааш зан” гэсэн утгыг илэрхийлж байжээ. Тэгэхлээр “*gut Wetter machen*” гэдэг үг үгчилбэл тэнгэр сайхан болгох буюу монголчилбол “тал засах” гэдэг хэллэгтэй яв цав дүйх ажээ.

Герман хэлний “*Heulen wie ein Schlosshund*” (цайзын нохой шиг ялин хуцах) цайзын хашаан дотор үргэлж ганцаараа байдаг нохой уйдаж, ганцаардан байнга улин хуцаж байдаг аж. Хэн нэгэн энгэнэтэл уйлж байвал германчууд дээрхтэй адилтгасан шилжсэн утгаар “цурхиран уйлах” -ыг хэлдэг байна.

Герман хэлний “*Jedes Wort auf die Goldwaage legen*” (үг бүрээ алт, мөнгөний дэнсэн дээр жинлэх) алт, мөнгө, эрдэнийн чулуу гэдэг асар үнэтэй учраас өчүүхэн жижиг үртэс, хэлтэрхийг ч гэсэн маш нарийн жинлүүр дээр тавьж жинлэдэг. Гэтэл хүнийг аварч ч болох, бас алж ч чадах хүчтэй үгийг “бас нарийн жинлэх” хэрэгтэй гэсэн санааг шилжсэн утгаар хэлэхийн өмнө сайтар бодож цэгнэж байж хэлэх ёстой хэмээн Мартин Лютер библийн судрыг орчуулахдаа энэхүү метафорчлолыг хэрэглэжээ.

Герман хэлний “*Jemandem die Hucke* ⁸² *volllügen*” (үүргийг нь дүүртэл молигодох) үүрэг гэдэг ямар нэгэн биетэй, бодтой зүйлийг хийдэг сав. Түүгээрээ дүүрэн юм хийгээд үүрэх юм бол маш хүнд байж таарна. Гэтэл унаж тустал, бууж мордтол хуурахыг германчууд шилжсэн утгаар үүргийг нь дүүртэл юм чихсэнтэй адилтгажээ.

Герман хэлний “*Jemandem die Würmer aus der Nase ziehen* ⁸³” (хэн нэгний хамраас өт чангаан гаргаж ирэх) хэн нэгний ам хамрыг чангааж байж, ганц нэг үг хэлүүлэхийг ийнхүү метафорчлон хэлсэн байна.

Герман хэлний “*Aus dem Stegreif* ⁸⁴” (дөрөөн дээрээс) гэдэг нь дөрөө мулталж мориноосоо буулгүйгээр хийчих гэсэн утгатай. Ямар нэгэн юмыг урьдчилан бэлтгэлгүйгээр шууд хийж орхихыг мориноосоо буулгүй, бүр дөрөө мултлалгүй хийлээ хэмээн тусгайлан ажил болгож бэлтгэхгүйгээр хийчихийг хэлнэ. Монголоор

⁸¹ Энэ хэлц үгэнд “Wetter” гэдэг үг “ааш зан” гэсэн утга илэрхийлж байгаа ажээ.

⁸² Герман хэлний *die “Hucke”* гэдэг нь хуучин цагийн үүрэг, ачаа гэсэн утгатай үг ажээ. Худал хэлж ачаа үүрүүлэх гэсэн утгатай ажээ.

⁸³ Дээр үед анагаах ухаан хөгжөөгүй байхад өвчтэй хүний хамарт өт орсноос бие нь өвдөж байна хэмээн ятгаад их сүр бадруулан хамрыг ухаад үүнийг гаргалаа хэмээн тусгай бэлдэж очсон өтнүүдээ гаргаж хаяхад тэр хүн санаагаараа бие сайжирдаг байжээ.

⁸⁴ Герман хэлний *Steg-reif* (мордох дээс) гэдэг хуучирсан үг бөгөөд төмөр дөрөө гараагүй бүр эмээл буй болоогүй байхад гогцоотой шидэмс мориныхоо нуруун дээр тохоод түүндээ хөлийнхөө өлмийг углан морддог байсан үед гарсан “дээсэн дөрөө” ажээ.

бол "балин тахил орохгүй"(огт бэлтгэлгүй, шууд) гарын үзүүрээр хийчих зүйл гэсэн утгатай ажээ.

Герман хэлний "Beleidigte Leberwurst" (гомдож орхисон элгэн хиам) гэдэг хэлц хиамын үйлдвэрийнхнээс гаралтай ажээ. Олон төрлийн хиам чанаж байхад хамгийн эхлээд түргэн болдог хиамнуудыг гаргасаар хамгийн сүүлд элгэн хиамыг гаргах хооронд элгэн хиам гомдож орхидог гэсэн хошин үг гарчээ. Ямар нэгэн юманд гомдоод "хумсаа чамласан хүүхэд шиг" урвайж хоцорсон байвал дээрхтэй адилтгадаг байна.

Германы хэлний "Damoklesschwert" (Дамоклесийн илд) хэмээх хэлц байдаг. Дамоклесийн илдний учрыг тайлбарлах аваас: Домогт гардгаар Сиракус хааны зарц Дамоклес гэж байжээ. Хаан нь түүнийг ертөнцийн хамгийн аз жаргалтай хүн хэмээн магтсанд тэр сэтгэл хангалуун байжээ. Хаан нь түүнд хаан ширээгээ шилжүүлэх бодолтой байж. Харин хаан ширээнд суулгахын өмнө нэгэн хүнд гэгчийн илдийг адууны сүүлний ганц хялгасаар оосорлон суудал дээр нь зүүжээ. Хэзээ хялгас тасран илд толгой дээр нь унахыг хэн ч тааварлаж эс мэднэ. Сиракус аз жаргал удаан үргэлжилдэггүй, алхам тутамд золгүй явдал дагаж байдаг гэдгийг мэдүүлэх гэсэн ажээ. Эдүгээ ч гэсэн хүмүүсийн толгой дээр Дамоклесийн илд савлаж байдаг ажгуу.

Германчууд "Дамоклесийн илд" -ийн шилжсэн утгаар "гай зовлон"-г илэрхийлсэн байна.

Герман хэлний "Das geht auf keine Kuhhaut" (Ямар ч үхрийн ширэн дээр багтахгүй) гэдэг хэлцийн утгыг тайлах аваас: Европод цаас хэрэглэдэг болохоос өмнө фергамент хэмээх үхрийн адсага, ямааны турсгаар хийсэн самбар дээр юм бичдэг байжээ. Нэг хүний насан туршдаа үйлдсэн нүглийг чөтгөр нэг фергамент дээр бичдэг хэмээн ярьдаг байжээ. "Хэрээс хэтэрсэн, хүлцэшгүй, зөвшөөршгүй, ичгүүргүй, үнэмшмээргүй юм" гэхийг дээрх энэхүү (энэ чинь ямар ч үхрийн ширэн дээр багтахгүй) хэмээх шилжсэн утгаар хэрэглэдэг байна.

Зөвхөн өвөрмөц хэлцэд төдийгүй танин мэдэхүй, гүн ухааны аястай ертөнцийн гуравт ч бас зүйрлэл, адилтгалыг монголчууд түгээмэл хэрэглэсэн байдаг. Тухайлбал ертөнцийн гурван цэмцгэрт монгол хүнд хамгийн ойр, байнга анзаарагддаг байгаль, цаг уурын үзэгдэл, ахуй амьдралын зүйл, хүний нүүр царайг ийнхүү хоршуулан адилтгасан байна.

Аль ч ард түмний сэтгэлгээ, өвөрмөц хэллэгт нэг юманд байдаг хэв шинжийг өөр нэг юмс үзэгдэлд шилжүүлэн хэрэглэж утга санаагаа тодотгох нь хэвийн зүйл болох саяын авсан цөөн тооны хэдэн жишээнээс харагдаж байна.

Дүгнэлт

Метафорчлах буюу утга шилжүүлэн хэрэглэх

Метафор нь латин хэлний “metaphora” (зөөвөрлөх), грек хэлний “μεταφορά” (шилжүүлэх) гэх мэт утгатай үгнээс үүдэлтэй ажээ. Өөрөөр хэлбэл, нэг зүйлд шууд утгаар хэрэглэдэг хэллэгийг өөр нэг зүйлд шилжсэн утгаар хэрэглэхийг метафорчлах гэж хэлдэг байна хэмээн ойлгож болох мэт санагдах ажээ.

Ийнхүү утга шилжүүлэн хэрэглэсэн өвөрмөц хэлц хэвшмэл хэллэг болох нь түгээмэл байдаг байна. Ийнхүү шилжмэл утгатай өвөрмөц хэлц хүн нийгмийн хөгжлийн тодорхой нэг үе шатанд хүмүүсийн сэтгэлгээний өвөрмөц хэлбэр болж орж ирэх бөгөөд мөн тухайн цаг үе нь өнгөрөхөд бас алгуур мартагдах нь олонтаа ч түүхэнд цаг үеийн ном зохиол, хэвлэлд хуучирсан үг, хэллэг болж үлдэх нь цөөнгүй. Тухайлбал, “улаан коммунист” гэдэг үг байна.

Ном зүй:

(HERMANN PAUL, PRINZIPIEN DER SPRACHGESCHICHTE, Zweiundzwanzigstes Kapitel.

Sprachmischung, z.n. Projekt Gutenberg)

Доржийн Дашдаваа, Орчуулгын найруулга зүйн бүтэц-утга зүйн үндэс,
Улаанбаатар хот, 2010

Etymologischen Wörterbuch der deutschen Sprache «von Friedrich Kluge, Berlin 2002,
Görner Redensarten Kleine Idiomatik der deutschen Sprache ...

Redensarten und ihre Bedeutung Weltbild

die schönsten Redewendungen garant

Wörterbuch Mongolisch-Deutsch Langenscheidt Verlag Enzyklopadie

Geflügelte Worte

Zitate, Sentenzen und Begriffe in ihren geschichtlichen Zusammenhang 1981